

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 11 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Г Хорооны 2009 оны 153 дугаар тогтоолд 7
нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.8, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 153 дугаар тогтоолд дор дурдсан агуулгатай заалт нэмж оруулсугай:

“3. Энэ тогтоолын 2-т заасан хугацаанаас өмнө ердийн, урт хугацааны болон давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч Хороонд хандсан хуулийн этгээд дүрмийн сангаа энэ тогтоолын 1-д заасан хэмжээгээр бүрдүүлсүгэй”.

2. Хорооны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” гэсэн 153 дугаар тогтоолын 3 гэсэн дэс дугаарыг 4 болгон өөрчилсүгэй.

3. Тогтоолд нэмэлт өөрчлөлтийг оруулж олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН